



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 54

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 39,050,000 /гучин есөн сая тавин мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 11,389,583.31 /арван нэгэн сая гурван зуун наян есөн мянга таван зуун наян гурван төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 10-07 ДУА улсын дугаартай TOYOTA HIACE маркийн автомашиныг “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Л.Доржбат), “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театрын дарга (А.Ууганбаяр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
54 дүгээр тогтоолын хавсралт

Аймгийн Засаг даргын тамгын газрын балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн он | Ашиглалт ад орсон огноо | Тээврийн хэрэгслийн | | | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өрөг |
|----------------------|---------------------------|--------------|------------------|--------|-----------------|-------------------------|---------------------|-----------------------------|------------------------|-----------------|---------------------------|--|---|
| | | | Серийн дугаар | Дугаар | | | Арлын дугаар | Моторын дугаар | Моторын эзлэхүүн /см3/ | | | | |
| 1 | Автобус | TOYOTA HIACE | ДУА | 10-07 | 2012 | 2020-12-13 | TRH2280 004990 | CBFT RH22 8BLE PDK | 2672.D | 27558 3 | 39,050,000 | 11,389,583.3 1 | 27,660,416.6 9 |
| Хөрөнгийн дүн | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | 39,050,000 | 11,389,583.3 | 27,660,416.6 |
| | | | | | | | | | | | /гучин есөн сая | 1 /арван нэгэн сая | 9 /хорин долоон сая |
| | | | | | | | | | | | тавин мянга/ төгрөг | гурван зуун наян есөн мянга | зургаан зуун жаран мянга |
| | | | | | | | | | | | | таван зуун наян гурван төгрөг | дөрвөн зуун арван зургаан төгрөг |
| | | | | | | | | | | | | гучин нэгэн мөнгө/ төгрөг | жаран есөн мөнгө/ төгрөг |